



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 4/108

Мандалговь

Бруцеллёзын дархлаажуулалтыг
зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7 дах заалтууд, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн А/179 тоот тушаал, аймгийн Засаг даргын 2021 оны 08 сарын 06-ны өдрийн А/273 тоот захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 2021 оны 08 дугаар сард багтаан зохион байгуулсугай.

2. Малчид, мал бүхий иргэдэд зарыг хүргэж бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд хурга, ишиг, тугалыг бүрэн хамруулж, чанартай гүйцэтгэхийг багийн Засаг дарга нар, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт үүрэг болгосугай.

3. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр ханган, шуурхай үр дүнтэй зохион байгуулж хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга, улсын байцаагч (Е.Отгонцэцэг), тархвар зүйч эмч (Д.Эрдэнэцэцэг) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



И.ЭРДЭНЭЦОГ